



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2016 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

Сэтгэцийн эмгэгтэй хөгжлийн бэрхшээлтэй хэвтэн эмчлүүлэгчдэд төрөөс олгож буй халамжийн мөнгөнд зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, Нийгмийн халамжийн тухай 12 дугаар зүйлийн 12.1.3, 15 дугаар зүйлийн 15.3, Удирдлагын зөвлөлийн гишүүдийн 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Асрамжийн клиникээс бусад клиникт хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгчдэд төрөөс олгож буй халамжийн мөнгийг зөвхөн тухайн клиникийн ахлах сувилагч хариуцан авч тухайн эмчлүүлэгчдэд шаардлагатай эд зүйлийг худалдан авч өгөн, шаардлагагүй тохиолдолд эмчлүүлэгчийн нэр дээр хадгаламжийн данс үүсгэж зарцуулалтыг нэг бүрчлэн хөтлөж сар бүр клиникийн эрхлэгч нарт, хагас, бүтэн жилээр Чанарын албаны дарга /Н.Оюунчимэг/-т тайлагнаж байхыг үүрэг болгосугай.

2. Асрамжийн клиникт эмчлүүлж байгаа эмчлүүлэгчдэд төрөөс олгож буй халамжийн мөнгийг Эмчлүүлэгчдийн нийгмийн асуудал болон аж ахуйн эд хөрөнгө хариуцсан няравын үүрэгт ажлыг түр орлон гүйцэтгэгч /Ц.Тэгшжаргал/-д хариуцуулан сар бүр дээрхи зарчмаар ажиллахыг үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтийг боловсронгуй болгох, клиникийн эрхлэгч, ахлах сувилагч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал /О.Ганчулуун/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ

020421